



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



THE WORLD BANK
IBRD - IDA | WORLD BANK GROUP



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ
THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION



ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022 ОНЫ I УЛИРАЛ

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.rilsp.gov.mn



Хөдөлмөрийн зах
зээлийн тойм-2022 I
улирал



Цалин хөлсний
бүтцийн
судалгаа-2021 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	04
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	04
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	07
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд	07
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд	15
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд	19
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	23
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	23
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	27
ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЦИЙН СУДАЛГАА-2021 ОН	32
Судалгааны хураангуй	32
Цалин хөлсний бүтэц, нийт цалин	32
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс бага хэмжээгээр цалинжиж буй ажиллагчид	34
Ажлын цагийн үзүүлэлт	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн.....	8
Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	11
Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар	15
Хүснэгт 4. Тэтгэвэр авагчдын тоо, төрөл, улирлаар	16
Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр.....	17
Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг.....	19
Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг.....	21
Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар.....	23
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар	25
Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, 2022 оны I улирал.....	25
Хүснэгт 11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд.....	28
Хүснэгт 12. Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, цалин тооцож буй нийт үзүүлэлт, мянган төгрөг	33
Хүснэгт 13. ААНБ-уудын ажиллагчдын нийт цалингийн дундаж, салбараар, мян.төг	34
Хүснэгт 14. Ажиллагчдын тоо, үндсэн цалин бүлгээр.....	34


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2022 оны I улирал.....	7
Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	8
Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2022 оны I улирал	9
Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны I улирал.....	10
Зураг 5. Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр, 2022 оны I улирал.....	10
Зураг 6. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, улирлаар, мянган хүн	11
Зураг 7. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар	12
Зураг 8. Ажиллагчдын тоо, ажилгүйдлийн түвшин, улирлаар.....	12
Зураг 9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин.....	13
Зураг 10. Сайн дурын даатгуулагчийн тоо, улирлаар	16
Зураг 11. Тэтгэвэр авагчид, төрлөөр, хувиар	17
Зураг 12. Нийгмийн даатгалын зарлагад эзлэх орлогын хувь, сараар.....	18
Зураг 13. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар.....	18
Зураг 14. Ажиллагчид, цалин хөлсний бүтцээр, дүнд эзлэх хувь, медиан цалин, улирлаар.....	19


Зураг 15. Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар	20
Зураг 16. Бодит цалингийн индекс (2015=100%), улирлаар	21
Зураг 17. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар	24
Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2022 оны I улирал	24
Зураг 19. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны I улирал	26
Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, хүйсээр, 2022 оны I улирал	27
Зураг 21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, 2021-2023 он	27
Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, хувиар	28
Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он	29
Зураг 24. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он	30
Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он	30
Зураг 26. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он	31
Зураг 27. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэд арга хэмжээний төрлөөр, 2021 он	31
Зураг 28. Хүүхэд хамгаалах төсөлд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгөөр	31
Зураг 29. Дундаж цалин, хүйс, бүтцээр, 2019-2021 он	32
Зураг 30. ААНБ-уудын нийт цалинг тооцож буй үзүүлэлт, хувиар	33
Зураг 31. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнээс бага цалин авсан ажиллагчид, сард ажилласан өдрөөр	35
Зураг 32. Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчид, ААНБ-ын хариуцлагын хэлбэр, хувиар	35

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022 ОНЫ I УЛИРАЛ

2022 оны I улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 232.9** мянга (58.0 хувь) нь ажиллах хүч, **892.8** мянга (42.0 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.



АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн



ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДТАЙ 3 САЛБАР



АЖИЛГҮЙ ИРГЭД



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



www.rilsp.gov.mn



(976)-77111331



[https://info@rilsp.gov.mn](mailto:info@rilsp.gov.mn)



<https://www.facebook.com/institute.mn/>


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2022 оны I улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2125.7 мянган хүн байгаагийн 1232.9 мянга (58.0 хувь) нь **ажиллах хүч**, 892.8 мянга (42.0 хувь) нь **ажиллах хүчнээс гадуурх хүн ам** байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 20.0 мянга буюу 0.9 хувиар нэмэгдсэн байна.

Нийт ажиллах хүчний 54.3 хувь нь эрэгтэйчүүд, 45.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 37.8 хувь нь эрэгтэйчүүд, 62.2 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2022 оны I улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 76.9 мянгаар, өмнөх улирлаас 6.4 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд 95.7 хувь нь ажиллагчдын тооны өөрчлөлтөөс, 4.2 хувь нь ажилгүй иргэдийн тооны өөрчлөлтөөс шалтгаалсан. Ажиллах хүч нэмэгдэхэд ажиллагчдын тоо 73.5 мянгаар, ажилгүй иргэдийн тоо 3.2 мянгаар нэмэгдэж нөлөөлжээ.

Ажиллах хүчний 1128.5 мянга (91.5 хувь) нь **ажиллагчид**, 104.4 мянга (8.5 хувь) нь **ажилгүйчүүд** байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 73.5 мянгаар (7.0 хувь), өмнөх улирлаас 1.3 мянгаар (0.1 хувь) нэмэгдсэн байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 3.2 мянгаар (3.2 хувь), өмнөх улирлаас 5.0 мянгаар (5.0 хувь) өссөн дүнтэй байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 56.9 мянга буюу 6.0 хувиар буурсан бол мөн хугацаанд боломжит ажиллах хүч 57.3 хувиар буурч, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.6 хувиар нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хүн ам 2022 оны I улирлын байдлаар улсын хэмжээнд 155.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 61.3 мянга буюу 28.3 хувиар буурсан. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 104.4 мянга (67.4 хувь) нь **ажилгүй хүн**, 4.0 мянга (2.6 хувь) нь **цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч**, 46.5 мянга (30.0 хувь) нь **боломжит ажиллах хүч** байна.


Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2021				2022	Өсөлт/Бууралт (Өмнөх)	
	I	II	III	IV	I	Он	Улирал
Ажиллах хүч	1156.1	1207.0	1226.8	1226.5	1232.9	76.9	6.4
Үүнээс: эмэгтэй	542.4	561.4	582.5	583.6	563.4	21.0	-20.2
Ажиллагчид	1054.9	1105.7	1135.9	1127.1	1128.4	73.5	1.3
Үүнээс: эмэгтэй	501.1	513.1	539.6	540.3	525.7	24.6	-14.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	2.8	8.3	6.8	4.0	-2.3	-2.8
Үүнээс: эмэгтэй	2.8	1.2	3.7	3.9	1.4	-1.4	-2.5
Ажилгүй хүн	101.2	101.3	90.9	99.4	104.4	3.2	5.0
Үүнээс: эмэгтэй	41.3	48.3	42.9	43.3	37.6	-3.7	-5.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	949.7	917.0	893.8	878.2	892.8	-56.9	14.6
Үүнээс: эмэгтэй	588.0	579.5	569.4	541.5	555.3	-32.7	13.8
Боломжит ажиллах хүч	108.8	71.8	54.2	45.1	46.5	-62.3	1.4
Үүнээс: эмэгтэй	54.8	38.1	30.1	20.5	23.7	-31.1	3.2
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	840.9	845.1	839.6	833.1	846.3	5.4	13.2
Үүнээс: эмэгтэй	533.1	541.4	539.2	521.0	531.6	-1.5	10.6
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	216.3	175.8	153.4	151.3	155.0	-61.3	3.7
Үүнээс: эмэгтэй	98.9	87.6	76.8	67.7	62.7	-36.2	-5.0

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо 2022 оны I улиралд 1128.4 мянга болж 2021 оны I улиралтай харьцуулахад өссөн хэдий ч 2019, 2020 оны I улирлын түвшин арай хүрээгүй байна. 2021 оны II улирлаас буюу цар тахлын үеийн хорио, хязгаарлалтын дэглэмийг сулруулж эхэлснээс хойш хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны I улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 10 хүн тутмын 4-5 нь (48.0 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин,

мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэгийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2022 оны I улирал




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны I улирлын байдлаар ажиллагчдын тооны өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал салбар бүр харилцан адилгүй байна. Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их өссөн салбаруудыг авч үзвэл, боловсруулах үйлдвэрлэл 26.9 мянгаар, боловсрол 12.9 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 9.8 мянгаар, Уул уурхай, олборлолт 7.0 мянгаар, барилгын салбар 6.6 мянгаар тус бүр нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их буурсан салбаруудыг авч үзвэл, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 7.0 мянгаар, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 4.2 мянгаар, Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 3.9 мянгаар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 3.1 мянгаар тус бүр буурсан байна.


Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн, 2022 оны I улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 753.8 мянга (66.8 хувь) нь хот, суурин газарт, 374.6 мянга (33.2 хувь) нь хөдөө орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 488.9 мянга (43.3% хувь) нь Улаанбаатар хотод, 150.6 мянга (13.4% хувь) нь Баруун бүсэд, 227.1 мянга (20.1% хувь) нь Хангайн бүсэд, 176.5 мянга (15.6% хувь) нь Төвийн бүсэд, 85.3 мянга (7.6% хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хангайн бүс 12.0 мянгаар (5.6 хувь), Төвийн бүс 2.3 мянгаар (1.3 хувь), Улаанбаатар хот 71.5 мянгаар (17.1 хувь) нэмэгдсэн бол Баруун бүс 6.8 мянгаар (4.3 хувь), Зүүн бүс 5.4 мянгаар (6.0 хувь) буурсан байна.

Зураг 5. Ажиллагчдын тоо, хот, хөдөө, бүсээр, 2022 оны I улирал




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны I улирлын байдлаар ажилгүй 104.4 мянган иргэн байгаагийн 66.8 мянга (64.0 хувь) нь эрэгтэй, 37.6 мянга (36.0 хувь) нь эмэгтэйчүүд байна. Өөрөөр хэлбэл ажилгүй байгаа 3 хүн тутмын хоёр нь эрэгтэйчүүд байна. Ажилгүй иргэний тоо өмнөх оны мөн үеэс 3.3 мянга буюу 3.2 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажилгүй эрэгтэйчүүд 7.0 мянга буюу 11.6 хувиар нэмэгдсэн бол эмэгтэйчүүд 3.7 мянга буюу 8.9 хувиар буурсан байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 43.3 хувь нь, Хангайн бүсэд 20.5 хувь нь, Баруун бүсэд 19.5 хувь нь, Төвийн бүсэд 13.1 хувь нь, Зүүн бүсэд 3.6 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хангайн бүс 7.5 мянгаар, Баруун бүс 2.8 мянгаар нэмэгдэж ажилгүйчүүдийн тооны өсөлт нөлөөлсөн. Харин бусад бүс нутгийн хувьд ажилгүйчүүдийн тоо буурсан байна. Үүнд, Төвийн бүс 4.4 мянгаар, Зүүн бүс 1.4 мянгаар, Улаанбаатар хот 1.2 мянгаар тус бүр буурчээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 18.6 мянга (17.8 хувь) нь 15-24 насны, 32.4 мянга (31.1 хувь) нь 25-34 насны, 31.9 мянга (30.6 хувь) нь 35-44 насны, 17.1 мянга (16.4 хувь) нь 45-54 насны, 4.4 мянга (4.2 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо өсөхөд 35-44 насны ажилгүйчүүд голчлон нөлөөлсөн ба өмнөх оны мөн үеэс 11.1 мянга буюу 53.3 хувиар нэмэгджээ. Харин эсрэгээр, 15-24 насны ажилгүй залуучуудын тоо өмнөх оны мөн үеэс 6.4 мянга буюу 25.5 хувиар буурчээ.

Зураг 6. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, улирлаар, мянган хүн



Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт	2021				2022	Өсөлт/Бууралт (Өмнөх)		
	I	II	III	IV	I	Он	Улирал	
Бүгд	101.2	101.3	90.9	99.4	104.4	3.3	5.0	
Хүйс	Эрэгтэй	59.8	52.9	48.0	56.1	66.8	7.0	10.8
	Эмэгтэй	41.3	48.3	42.9	43.3	37.6	-3.7	-5.7
Насны бүлэг	15-24	24.9	17.6	18.8	17.9	18.6	-6.4	0.6
	25-34	35.7	35.4	26.0	29.8	32.4	-3.2	2.6
	35-44	20.8	23.4	24.5	25.1	31.9	11.1	6.8
	45-54	15.3	23.2	18.0	20.6	17.1	1.8	-3.5
	55+	4.5	1.7	3.5	5.9	4.4	-0.1	-1.5

Баруун	17.6	19.1	13.4	12.2	20.4	2.8	8.2	
Хангайн	13.9	14.6	24.5	27.2	21.4	7.5	-5.8	
Бүс	Төвийн	18.1	17.6	19.1	18.5	13.7	-4.4	-4.8
Зүүн	5.2	4.4	2.4	4.9	3.8	-1.4	-1.1	
Улаанбаатар	46.4	45.5	31.5	36.7	45.2	-1.2	8.5	

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн 35.5 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош түвшний, 28.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд, 35.7 хувь нь бакалавр, түүнээс дээш түвшний боловсролтой байна. Өөрөөр хэлбэл ажилгүй 3 хүн тутмын нэг нь бүрэн дунд болон түүнээс доош түвшний боловсролтой эсвэл бакалавр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 7. Ажилгүйдчүүд, боловсролын түвшнээр, хувиар


3 хүн
1 тутмын
нь бакалавр, түүнээс
дээш түвшний
боловсролтой байна




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 8.5 хувь болж өмнөх улирлаас 0.4 пунктээр нэмэгдсэн бол өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан. Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс буурахад эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 6.7 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурч, харин эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 10.0 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өсөж нөлөөлсөн байна.

Зураг 8. Ажиллагчдын тоо, ажилгүйдлийн түвшин, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий **ажиллах хүчний оролцооны түвшинг** улирлаар авч үзэхэд 2022 оны I улиралд 58.0 хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 пунктээр өссөн хэдий ч 2018, 2019 оны мөн үеэс 2.6-2.7 пунктээр бага байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2022 оны I улирлын байдлаар 53.1 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 пунктээр өссөн хэдий ч, 2018-2019 оны мөн үеэс бага байсаар байна.

Зураг 9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022 ОНЫ I УЛИРАЛ


ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ



ААНБ-ын төрлөөр



ТЭТГЭВЭР АВАГЧИД




ШИМТГЭЛИЙН ОРЛОГО



* Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

ДААТГУУЛАГЧ



Даатгуулагчид, төрлөөр



САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ



ЗАРЛАГА



Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 оны I улирлын байдлаар **шимтгэл төлөгч байгууллагын** тоо 48.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.2 мянга буюу 4.5 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 90.4 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.6 хувь нь төсөвт байгууллагууд байна. Хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 2.1 мянга буюу 4.8 хувиар, төсөвт байгууллагын тоо 81 буюу 1.8 хувиар нэмэгджээ.

Мөн 2022 оны I улирлын байдлаар нийгмийн даатгалд 891.8 мянган **даатгуулагч** даатгуулсан бөгөөд 107.4 мянга (12.0 хувь) нь **сайн дурын**, 784.4 мянга (88.0 хувь) нь **албан журмын даатгуулагч** байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 46.0 мянга буюу 4.0 хувиар нэмэгджээ.

Албан журмын даатгуулагчдын 68.8 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллагын, 31.2 хувь төсөвт байгууллагын ажиллагчид байна. Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 39.5 мянга буюу 4.1 хувиар нэмэгдсэн бөгөөд 91.1 хувь нь аж ахуй нэгж байгууллагын, 8.9 хувь төсөвт байгууллагын ажиллагчдын өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ			Даатгуулагч		
	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Нийт	Сайн дур	Албан журам
2019 I	42055	37355	4700	844403	139160	705243
II	44844	40299	4545	962480	160911	801569
III	46331	41767	4564	1063659	173892	889767
IV	47929	43353	4576	1168337	185986	982351
2020 I	42862	38286	4576	831943	108042	723901
II	46762	42185	4577	961692	156624	805068
III	47818	43225	4593	1051309	172892	878417
IV	49067	44442	4625	1156793	192090	964703
2021 I	46242	41668	4574	845802	100956	744846
II	48738	44137	4601	962387	136141	826246
III	50625	46001	4624	1062030	147827	914203
IV	52388	47732	4656	1181282	161111	1020171
2022 I	48462	43807	4655	891825	107417	784354

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2022 оны I улирлын байдлаар сайн дурын даатгалд 107.4 мянган даатгуулагч хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.5 мянга буюу 3.4 хувиар нэмэгджээ. Сайн дурын даатгуулагчдыг гол төрлөөр нь авч үзвэл, 13.5 хувь нь малчид, 5.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байгаа бөгөөд даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 4.1 мянга буюу 8.4 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.7 мянга буюу 12.4 хувиар буурсан дүнтэй байна.

Засгийн газраас хэрэгжүүлсэн Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс 2020 оны 10 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд сайн дурын даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлөх дэмжлэг үзүүлсэн нь 2020 онд сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо буурахаас сэргийлж чадсан. Харин 2021 он гарснаас хойш сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 2-4 дахин буурсан дүнтэй байна. Тухайлбал, сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 2019 оны I улиралд 23.0 мянга байсан бол 2022 оны I улиралд 5.5 мянга болж 4.2 дахин, сайн дураар даатгуулсан малчдын тоо 2019 оны I улиралд 34.0 мянга байсан бол 2022 оны I улиралд 14.5 мянга болж 2.3 дахин буурсан байна.

Зураг 10. Сайн дурын даатгуулагчийн тоо, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын сангаас **тэтгэвэр авагчдын** тоо 2022 оны I улирлын байдлаар 462.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 13.2 мянга буюу 2.9 хувиар нэмэгдсэн. Тэтгэвэр авагчдын 77.8 хувь нь **өндөр насны тэтгэвэр**, 13.7 хувь нь **тахир дутуугийн тэтгэвэр**, 4.2 хувь нь **тэжээгчээ алдсаны тэтгэвэр**, 4.3 хувь **цэргийн тэтгэвэр** авагчид байна. Өндөр насны тэтгэвэр авагчид 2021 оны IV улирлын байдлаар 359.8 мянга болж өмнөх оны мөн үеэс 15.5 мянга буюу 4.5 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид 19.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 77 буюу 0.4 хувиар, цэргийн тэтгэвэр авагчид 19.8 мянга болж өмнөх оны мөн үеэс 520 буюу 2.7 хувиар нэмэгдсэн бол тахир дутуугийн тэтгэвэр авагчид 63.4 мянга болж өмнөх оны мөн үеэс 2.9 мянга буюу 4.4 хувиар буурчээ.


Хүснэгт 4. Тэтгэвэр авагчдын тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2019 I	408873	301848	68326	20372	18327
II	410992	304022	68318	20215	18437
III	414404	306906	68710	20179	18609
IV	418379	310955	68475	20184	18765

2020 I	427247	320602	67912	19853	18880
II	434186	327799	67663	19711	19013
III	439481	333026	67769	19584	19102
IV	444788	338982	67018	19553	19235
2021 I	449419	344287	66344	19511	19277
II	451845	347235	65771	19377	19462
III	454298	350091	65197	19437	19573
IV	456365	353775	63318	19563	19709
2022 I	462607	359783	63439	19588	19797

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 11. Тэтгэвэр авагчид, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2022 оны I улирлын байдлаар 563.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 125.1 тэрбум төгрөг буюу 28.6 хувиар, **нийгмийн даатгалын зарлага** 759.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 136.7 тэрбум төгрөг буюу 22.0 хувиар нэмэгдсэн. 2022 оны I улирлын байдлаар шимтгэлийн орлогын 83.6 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.2 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 6.7 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 1.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 92.1 хувийг тэтгэврийн даатгалын сан, 4.7 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 1.0 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Орлого, зарлагын зөрүү 2021 оны I улиралд 184.3 тэрбум төгрөг байсан бол 2022 оны I улиралд 195.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 6.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр


Үзүүлэлт	2020 IV	2021 IV		Өөрчлөлт		
		Эзлэх хувь	2021 IV	Эзлэх хувь	Тоо	Хувь
НД-ын шимтгэлийн орлого	437.9	100.0%	563.1	100.0%	125.1	28.6%
Тэтгэвэр	385.5	88.0%	470.6	83.6%	85.1	22.1%
Тэтгэмж	25.3	5.8%	46.2	8.2%	20.9	82.3%
ҮОМШӨ	22.2	5.1%	37.5	6.7%	15.3	68.8%
Ажилгүйдэл	4.9	1.1%	8.7	1.5%	3.8	79.1%
НД-ын зарлага	622.3	100.0%	759.0	100.0%	136.7	22.0%
Тэтгэвэр	561.8	90.3%	699.2	92.1%	137.5	24.5%

Тэтгэмж	39.8	6.4%	36.0	4.7%	-3.8	-9.6%
ҮОМШӨ	7.1	1.1%	7.8	1.0%	0.7	9.7%
Ажилгүйдэл	13.6	2.2%	15.9	2.1%	2.3	17.1%
Орлого, зарлагын зөрүү	-184.3	-	-195.9	-	-11.5	6.3%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2019 оны I улирлын байдлаар нийгмийн даатгалын сангийн зарлагын 78.0 хувийг шимтгэлийн орлого эзэлж байсан бол 2020 оны мөн үед 73.7 хувийг, 2021 оны мөн үед 70.4 хувийг эзэлж байсан бол 2022 оны I улиралд 74.2 хувь болж өмнөх оноос 3.8 пунктээр өссөн байна.

Зураг 12. Нийгмийн даатгалын зарлагад эзлэх орлогын хувь, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2022 оны I улирлын байдлаар 6.7 мянган иргэн хамрагдаж, тэтгэмж болгож 15.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 0.3 мянга буюу 3.8 хувиар буурсан бол тэтгэмжид зарцуулсан хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум төгрөг буюу 17.1 хувиар нэмэгджээ.

2021 оны I улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 2.0 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2022 оны I улиралд 2.4 сая болж, 21.8 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 13. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

САРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аж ахуй нэгж байгууллагын **ажиллагчдын сарын дундаж цалин** сүүлийн жилүүдэд тогтмол өссөөр байсан бөгөөд 2021 оны IV улирлын байдлаар дундаж цалин 1438.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 110.1 мянга буюу 8.3 хувиар, өмнөх улирлаас 103.1 мянга буюу 7.7 хувиар өссөн. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт гэдгийг анхаарах хэрэгтэй.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 1549.6 мянган төгрөг, эмэгтэйчүүд 1320.4 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2021 оны IV улиралд 229.2 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 28.4 мянгаар буурчээ.

Өөрөөр хэлбэл, 2021 оны IV улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 85.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр өсөж эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн ялгаа буурсан байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг


Үзүүлэлт	2020	2021				Өсөлт/Бууралт (Өмнөх)	
	IV	I	II	III	IV	Он	Улирал
Дундаж цалин	1328.1	1314.9	1330.4	1335.1	1438.2	110.1	103.1
Эрэгтэй	1452.9	1461.5	1439.9	1462.5	1549.6	96.7	87.1
Эмэгтэй	1195.3	1158.9	1212.8	1201.7	1320.4	125.1	118.7

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2021 оны IV улирлын байдлаар медиан цалин 1068.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 72.2 мянга буюу 7.2 хувиар, өмнөх улирлаас 75.1 мянга буюу 7.6 хувиар нэмэгдсэн байна. Медиан цалингийн өсөлт дундаж цалингийн өсөлтөөс их байгаа нь цалингийн ялгаа багасаж байгааг илэрхийлж байна.

2021 оны IV улиралд нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдын тоог цалин хөлсний бүтцээр авч үзвэл, 27.1 хувь нь 700.0 мянга хүртэлх төгрөг, 24.7 хувь нь 700.0-1100.0 мянган төгрөг, 31.7 хувь нь 1100.0-2000.0 мянган төгрөг, 16.5 хувь нь 2000.0-аас дээш мянган төгрөгийн цалинтай ажиллагчид байна.

Зураг 14. Ажиллагчид, цалин хөлсний бүтцээр, дүнд эзлэх хувь, медиан цалин, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн их (3212.2 мянга), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн бага (967.9 мянга) байна.

Уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 1774.0 мянга буюу 123.3 хувиар их байгаа бол зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 470.3 мянга буюу 32.7 хувиар бага байна.

Ажиллагчдын сарын дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 311.1 мянган (24.9 хувь), олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа 269.7 мянган (13.8 хувь), санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 242.0 мянган (16.6 хувь) төгрөгөөр нэмэгдсэн бол уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 83.8 мянга буюу 2.5 хувиар буурсан дүнтэй байна.

Зураг 15. Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2021 оны IV улирлын дундаж цалинг ажиллагчдын тооны бүлгээр өмнөх оны харьцуулахад, 1-9 ажиллагчидтай ААНБ дундаж цалин 75.4 мянгаар (9.3 хувь), 10-49 ажиллагчидтай ААНБ-ынх 148.4 мянгаар (14.1 хувь), 50-99 ажиллагчидтай ААНБ-ынх 117.2 мянгаар (9.7 хувь), 100-99 ажиллагчидтай ААНБ-ынх 113.2 мянгаар (8.3 хувь), 200, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ынх 75.0 мянгаар (4.0 хувь) нэмэгджээ. Тоон мэдээллээс харахад 100, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 3.5-35.9 хувиар их байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг


Ажиллагчдын тооны бүлэг	2020 IV			2021 IV			Өөрчлөлт	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	1328.1	1452.9	1195.3	1438.2	1549.6	1320.4	110.1	8.3%
1-9	813.7	824.9	802.7	889.1	900.0	878.1	75.4	9.3%
10-49	1052.1	1056.4	1048.4	1200.5	1192.5	1207.7	148.4	14.1%
50-99	1204.3	1249.9	1160.4	1321.5	1397.5	1250.5	117.2	9.7%
100-199	1375.3	1457.9	1290.0	1489.0	1573.7	1401.9	113.7	8.3%
200 дээш	1878.8	2098.6	1569.4	1953.8	2146.2	1693.2	75.0	4.0%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2015 оныг суурь болгосон нэрлэсэн цалингийн индекс 2021 оны IV улиралд 78.0 хувиар нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлдэг бодит цалингийн индекс 25.7 хувиар нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд бодит худалдан авах чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын ажиллагчдын цалинг огцом өсгөсөн нь эргээд зарим гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж инфляц үүсгэх хандлага ажиглагдсаар байна. Зарим гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөө нь хэрэглээний үнийн өсөлтийг тогтмол нэмэгдүүлсээр байгаа бөгөөд үүнээс шалтгаалж нэрлэсэн болон бодит цалингийн индексийн зөрүү холдох байдал нь хадгалагдсаар байна.

2020 оны IV улиралд нэрлэсэн болон бодит цалингийн индексийн зөрүү 32.7 пункт байсан бол 2021 оны IV улирлын байдлаар 52.3 болж жилийн хугацаанд 19.6 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 16. Бодит цалингийн индекс (2015=100%), улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2022 ОНЫ I УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА




АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН



ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, УЛСААР

5 463 Гадаадын иргэд = 4 752 (87.0%) Эрэгтэй + 711 (13.0%) Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨР ЗРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨДӨЛМӨР ЗРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор **ажил хайж байгаа иргэдийн** тоо 2022 оны I улирлын эцэст 24.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 0.9 мянга буюу 3.1 хувиар буурсан байна. Ажил хайж байгаа иргэдийн 12.2 мянга (50.4 хувь) нь эрэгтэйчүүд, 12.0 мянга (49.6 хувь) нь эмэгтэйчүүд байна. Ажил хайж байгаа иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 3.5 мянга (14.5 хувь) нь 15-24 насны, 8.8 мянга (36.2 хувь) нь 25-34 насны, 6.8 мянга (28.1 хувь) нь 35-44 насны, 4.1 мянга (16.9 хувь) нь 45-54 насны, 1.1 мянга (4.3 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн **бүртгэлтэй ажилгүй иргэний** тоо 16.6 мянга болж өмнөх оны мөн үеэс 0.2 мянга буюу 0.9 хувиар буурсан. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 8.3 мянга (49.8 хувь) нь эрэгтэйчүүд, 8.3 мянга (50.2 хувь) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 2.6 мянга (15.5 хувь) нь 15-24 насны, 6.2 мянга (37.3 хувь) нь 25-34 насны, 4.5 мянга (37.3 хувь) нь 35-44 насны, 2.6 мянга (15.8 хувь) нь 45-54 насны, 0.7 мянга (4.2 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч / сарын эцэст/			Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/		
		Эмэгтэй	Эзлэх хувь		Эмэгтэй	Эзлэх хувь
2019 I	31832	16466	51.7%	21752	11331	52.1%
II	33327	17255	51.8%	23045	12165	52.8%
III	30467	16250	53.3%	20413	11041	54.1%
IV	37044	19016	51.3%	20761	10887	52.4%
2020 I	31785	16285	51.2%	19394	10009	51.6%
II	30320	15367	50.7%	19563	10001	51.1%
III	27504	14301	52.0%	17829	9446	53.0%
IV	29952	15390	51.4%	18103	9535	52.7%
2021 I	25105	12774	50.9%	16775	8650	51.6%
II	26991	13837	51.3%	17650	9202	52.1%
III	21804	11316	51.9%	15053	7895	52.4%
IV	27950	14510	51.9%	18644	9821	52.7%
2022 I	24255	12019	49.6%	16622	8345	50.2%

Зураг 17. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшнээр авч үзвэл, 1.3 хувь нь боловсролгүй, 1.9 хувь нь бага, 5.9 хувь нь суурь, 52.3 хувь нь бүрэн дунд, 7.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 25.6 дипломын болон бакалаврын дээд, 0.9 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.1 хувь нь боловсролгүй, 1.8 хувь нь бага, 5.5 хувь нь суурь, 50.0 хувь нь бүрэн дунд, 7.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.1 дипломын болон бакалаврын дээд, 1.0 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2022 оны I улирал



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2022 оны I улиралд 9.3 мянган **ажлын байрны захиалга** ирсэн бөгөөд 3.9 мянган иргэнийг **ажилд зуучилж**, эрэлтийн 41.8 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 2.9 мянга буюу 38.3 хувиар, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 0.8 мянга буюу 18.6 хувиар нэмэгдсэн байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 0.8 мянга (20.8 хувь) нь 15-24 насны, 1.3 мянга (34.0 хувь) нь 25-34 насны, 1.0 мянга (25.9 хувь) нь 35-44 насны, 3.2 мянга (14.9 хувь) нь 45-54 насны, 0.2 мянга (4.4 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2022 оны I улиралд хөдөлмөрийн эрэлтийн 41.8 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.0 пунктээр буурчээ. Цар тахалгүй үе буюу 2019 оны I улиралтай харьцуулахад 12.7 пунктээр бага байна.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эрэлт хангасан хувь		
			Эмэгтэй	Эзлэх хувь	
2019 I	6710	3661	1977	54.0%	54.6%
II	27037	16903	8662	51.2%	62.5%
III	39989	24860	12738	51.2%	62.2%
IV	71124	44059	22244	50.5%	61.9%
2020 I	7595	4489	2307	51.4%	59.1%
II	28036	15250	7330	48.1%	54.4%
III	42433	21672	10858	50.1%	51.1%
IV	58022	33006	16651	50.4%	56.9%
2021 I	6413	3066	1545	50.4%	47.8%
II	20352	11416	5542	48.5%	56.1%
III	32656	17636	9068	51.4%	54.0%
IV	51034	29929	15460	51.7%	58.6%
2022 I	9322	3901	2003	51.3%	41.8%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2022 оны I улиралд ирсэн ажлын байрны захиалгын 33.5 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 21.6 хувь нь уул уурхай, олборлолт, 7.7 хувь нь барилга, 5.3 хувь нь боловсрол, 4.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 3.4 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 3.3 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбараас ирсэн захиалга байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, 2022 оны I улирал

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн		Эрэлт хангасан хувь	
		Эзлэх хувь	Эзлэх хувь		
Бүгд	9322	100.0%	3901	100.0%	41.8%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	216	2.3%	119	3.1%	55.1%
Уул уурхай, олборлолт	2014	21.6%	563	14.4%	28.0%
Боловсруулах үйлдвэрлэл	450	4.8%	154	3.9%	34.2%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	55	0.6%	41	1.1%	74.5%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	142	1.5%	47	1.2%	33.1%
Барилга	722	7.7%	276	7.1%	38.2%
Бөөний болон жижиглэн худалдаа	672	7.2%	157	4.0%	23.4%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	54	0.6%	69	1.8%	127.8%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	205	2.2%	79	2.0%	38.5%
Мэдээлэл, холбоо	21	0.2%	7	0.2%	33.3%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	92	1.0%	40	1.0%	43.5%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	52	0.6%	17	0.4%	32.7%

Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	2	0.0%	2	0.1%	100.0%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	315	3.4%	154	3.9%	48.9%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	242	2.6%	172	4.4%	71.1%
Боловсрол	496	5.3%	388	9.9%	78.2%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	311	3.3%	173	4.4%	55.6%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	89	1.0%	56	1.4%	62.9%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3120	33.5%	1359	34.8%	43.6%
Хүн хөслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	27	0.3%	12	0.3%	44.4%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	25	0.3%	16	0.4%	64.0%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ, ГАДААДАД АЖИЛЛАХ ХҮЧ ЗУУЧЛАХ

2022 оны I улирлын байдлаар **хөдөлмөрийн гэрээгээр гадаадын** 92 улсын 5463 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 1030 буюу 23.2 хувиар нэмэгджээ байна. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 4752 (87.0 хувь) нь эрэгтэйчүүд, 711 (13.0 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 36.6 хувь нь Улаанбаатар хотод, 5.8 хувь нь Баруун бүсэд, 5.3 хувь нь Хангайн бүсэд, 36.7 хувь нь Төвийн бүсэд, 15.6 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 3105 (56.8 хувь) нь Хятад, 277 (5.1 хувь) нь Орос, 269 (4.9 хувь) нь Энэтхэг, 251 (4.6 хувь) нь Өмнөд Солонгос, 209 (3.8 хувь) нь АНУ, 189 (3.5 хувь) нь Вьетнам, 176 (3.2 хувь) нь Австрали, 164 (3.0 хувь) нь Филиппин, 138 (2.5 хувь) нь Өмнөд Африк, үлдсэн 685 (12.5 хувь) нь бусад улсын иргэн байна.

Зураг 19. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны I улирал




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2022 оны I улирлын байдлаар 403 иргэн **хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан** бөгөөд 357 (93.5 хувь) нь Өмнөд Солонгос, 46 (6.5 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 377 (88.6 хувь) нь эрэгтэйчүүд, 26 (11.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Мөн ажил зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 10.9 хувь 20-24 насны, 25.1 хувь нь 25-29 насны, 42.4 хувь нь 30-34 насны, 14.4 хувь нь 35-39 насны, үлдсэн 7.2 хувь нь 40-49 насныхан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 44.9 хувь нь бүрэн дунд, 12.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 42.4 хувь нь бакалаврын болон түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, хүйсээр, 2022 оны I улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2021-2022 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 5 хөтөлбөр, 1 төслийн 17 арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 2022-2023 онд 7 хөтөлбөрийн 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Зураг 21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, 2021-2023 он

2021-2022	2022-2023
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр 1	1 Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 2	2 Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 3	3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 4	4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 5	5 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
	6 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
	7 Ногоон ажлын байр хөтөлбөр


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2021 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт нийт 39.8 мянган иргэнийг хамруулж, 18.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг хөтөлбөрийн төрлөөр авч үзвэл 16.6 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 23.4 хувь нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 8.6 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 2.4 хувь нь Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 48.6 хувь нь Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, 0.4 хувь нь Хүүхэд хамгаалах төсөлд тус тус хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг төсөл, хөтөлбөрөөр авч үзвэл 2.6 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 4.1 хувь нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 33.9 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 6.4 хувь нь Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 52.0 хувь нь Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, 1.0 хувь нь Хүүхэд хамгаалах төсөлд зарцуулсан байна.

Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан хүний тоо өмнөх оноос 10.4 мянга буюу 35.6 хувиар, зарцуулсан хөрөнгө 996.9 сая төгрөг буюу 5.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд

Үзүүлэлт	2020		2021		Эзлэх хувь	
	Хүний тоо	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо	Гүйцэтгэл /сая төг/
НИЙТ	29360	17998.4	39799	18995.3	100.0%	100.0%
Хөдөлмөрт бэлтгэх	2587	200.1	6596	497.9	16.6%	2.6%
Ажлын байрыг дэмжих	18577	9759.6	-	-	-	-
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2637	1158.8	9331	772.9	23.4%	4.1%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	2844	3376.9	3440	6432.8	8.6%	33.9%
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	884	989.6	941	1216.7	2.4%	6.4%


Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	-	-	19324	9880.2	48.6%	52.0%
Хүүхэд хамгаалах төсөл	233	239.2	167	194.8	0.4%	1.0%
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1598	2274.2	-	-	-	-

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 2021 онд 6.6 мянган иргэн хамрагдаж, 524 иргэн байнгын ажлын байраар хангагдаж, 497.9 сая төгрөг зарцуулсан байна. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд өмнөх оноос 4.0 мянга буюу 1.5 дахин нэмэгдсэн бол зарцуулсан хөрөнгө 297.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэдийг арга хэмжээний төрлөөр нь авч үзвэл, 2.0 мянга (30.0 хувь) нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, 2.0 мянга (30.7 хувь) нь ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт, 1.4 мянга (20.4 хувь) нь ажилд зуучлах уулзалтад бэлтгэх, 1.2 мянга (18.9 хувь) танхимын сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан байна.

Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд 9.3 мянган иргэн хамрагдаж, 772.9 сая төгрөгийг зарцуулж, байнгын 6.7 мянган ажлын байрыг бий болгосон байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд өмнөх оноос 6.7 мянга буюу 2.5 дахин нэмэгдсэн бол зарцуулсан хөрөнгө 385.9 сая төгрөг буюу 33.3 хувиар буурсан дүнтэй байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийг арга хэмжээний төрлөөр нь авч үзвэл, 116 (1.2 хувь) нь ажлын дадал туршлага эзэмшүүлэх үйлчилгээ, 1718 (18.4 хувь) нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ, 7497 (80.3 хувь) нь Цагийн ажилд зуучлах арга хэмжээнд хамрагдсан байна.

Зураг 24. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2021 онд 3.4 мянган иргэн хамрагдаж, 6.4 тэрбум төгрөгийг зарцуулж, байнгын 1.3 мянган ажлын байрыг бий болгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд өмнөх оноос 596 буюу 21.0 хувиар нэмэгдсэн бол зарцуулсан хөрөнгө 3.1 тэрбум төгрөг буюу 90.5 хувиар нэмэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийг арга хэмжээний төрлөөр нь авч үзвэл, 271 (7.9 хувь) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх, 962 (28.0 хувь) нь иргэн болон аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, 1334 (38.8 хувь) нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 35 (1.0 хувь) нь борлуулалтын дэмжлэг үзүүлэх, 56 (1.6 хувь) нь ажил олгогчид дэмжлэг үзүүлэх, 277 (6.6 хувь) нь ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх, 555 (16.1 хувь) нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан байна.

Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2021 онд 941 иргэн хамрагдаж, 12.2 тэрбум төгрөгийг зарцуулж, байнгын 417, түр 561 (нийт 978) ажлын байрыг бий болгосон байна. Тус хөтөлбөрт хамрагдсан иргэд өмнөх оноос 57 буюу 6.4 хувиар нэмэгдсэн бол зарцуулсан хөрөнгө 227.4 сая төгрөг буюу 22.9 хувиар нэмэгдсэн байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хөтөлбөрт хамрагдсан иргэдийг арга хэмжээний төрлөөр нь авч үзвэл, 560 (59.5 хувь) нь зөвлөх үйлчилгээнд, 381 (40.5 хувь) нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан байна.

Зураг 26. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2017-2021 он




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2021 онд шинээр хэрэгжсэн **Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт** 19.3 мянган иргэн хамрагдаж, 9.9 тэрбум төгрөгийг зарцуулж, 13.4 мянган (байнгын 2.3 мянга (16.9 хувь), түр 11.1 мянга (83.1 хувь)) ажлын байрыг бий болгосон байна.

Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдсан иргэдийг арга хэмжээний төрлөөр нь авч үзвэл, 6.2 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга, 22.1 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, 3.5 хувь нь малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, 5.2 хувь нь мал маллах арга ухааны сургалт, 4.9 хувь нь борлуулалтын дэмжлэг үзүүлэх, 0.6 хувь нь ажил олгогчийг дэмжих, 57.6 хувь нь нийтийг хамарсан ажил зохион байгуулахад хамрагдсан байна.

Зураг 27. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэд арга хэмжээний төрлөөр, 2021 он



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2021 оны жилийн эцсийн байдлаар **Хүүхэд хамгаалах төсөлд** 167 иргэн хамрагдаж, 194.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд түр 167 ажлын байрыг бий болгосон. Хүүхэд хамгаалах төсөлд хамрагдсан иргэд өмнөх оноос 66 иргэнээр, зарцуулсан хөрөнгө 44.4 сая төгрөг буюу 18.6 хувиар буурсан байна.

Зураг 28. Хүүхэд хамгаалах төсөлд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгөөр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЦИЙН СУДАЛГАА-2021 ОН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улс орны эдийн засгийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаанд чухал нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн нэг нь ААНБ-ын цалин хөлсний бүтэц, түүний тогтолцооны асуудал юм. Төрөөс цалин хөлсийг тогтоох тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, цалин хөлсний талаар үнэн бодитой статистик мэдээллээр хангах зорилгоор бид 2009-2010 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техникийн тусламжаар ҮСХ-той хамтран “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-г олон улсын арга, аргачлалын дагуу улсын хэмжээнд анх удаа хийж гүйцэтгэсэн. 2013 оноос эхлэн салбарын яамнаас “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-г хоёр жил тутамд явуулж байхаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 онд 5 дах удаагаа зохион байгуулж үр дүнг танилцуулсан.


Цалин хөлсний бүтцийн судалгаанд улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг энгийн санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн 2 474 (1 719 (69.5 хувь) нь Улаанбаатар, 755 (30.5 хувь) нь орон нутаг) байгууллагыг хамруулсан. Судалгаанд хамрагдсан ААНБ-уудад нийт 149.0 мянган ажиллагчид хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд үүний 15.5 хувь буюу 23.1 мянган ажиллагчдын мэдээллийг нэгтгэн үр дүнг тооцсон болно.

ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЭЦ, НИЙТ ЦАЛИН

Судалгааны үр дүнгээр улсын хэмжээнд ажиллагчдын нийт цалингийн дундаж 1 087.7 мянган төгрөг байна. Дундаж цалингийн 913.1 мянга (84.0 хувь) нь үндсэн цалин, 108.3 мянга (10.0 хувь) нь нэмэгдэл, 56.1 мянга нь (5.2 хувь) нь нэмэгдэл хөлс, 10.2 мянга нь (0.9 хувь) нь шагнал урамшуулаас бүрдэж байна.

Судалгааны дүнгээр ажиллагчдын цалингийн бүтцийг 2019 оны нийт цалингийн бүтэцтэй харьцуулбал 2021 оны нийт цалинд эзлэх үндсэн цалин 84.0 хувь болж 2.8 пунктээр, шагнал урамшуулал 0.9 хувь болж 0.4 пунктээр өмнөх судалгааны дүнгээс буурсан. Харин ажиллагчдын нэмэгдэл 2021 оны дүнгээр 10.0 хувь болж 2.5 пунктээр, нэмэгдэл хөлс 5.2 хувь байгаа нь 0.7 пунктээр өссөн байна.

Зураг 29. Дундаж цалин, хүйс, бүтцээр, 2019-2021 он



Ажил олгогчид ажиллагчдын ажилласан жил, үр чадвар мэргэжлийн зэрэг, ажлын гүйцэтгэл буюу хийснээр, ажлын байран дахь ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтийг дангаар нь, эсвэл хоёроос гурван үзүүлэлт харгалзан үндсэн цалинг тогтоодог байна.

Ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ажил олгогчдын 21.1 хувь нь ажиллагчдын ажилласан жилээр, 5.3 хувь нь ур чадвар мэргэжлийн зэргээр, 25.5 хувь нь ажлын гүйцэтгэл буюу хийснээр, 48.1 хувь нь ажлын байран дахь ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтээр үндсэн цалин тооцож байна.

Зураг 30. ААНБ-уудын нийт цалинг тооцож буй үзүүлэлт, хувиар



ААНБ-ын ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ангилан, нийт цалингийн хэмжээтэй харьцуулан харвал ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлээр буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалаар харгалзан тогтоосон цалин нийт дундаж цалингаас 121.3 мянган төгрөг буюу 11.2 хувиар, ур чадвар, мэргэжлийн зэрэг, ажил үүрэг албан тушаалаар харгалзан цалингаа тогтоолгосон ажиллагчдын цалин нийт дундаж цалингаа 79.4 мянган төгрөг буюу 7.3 хувиар өндөр байна. Харин ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлд суурилан тогтоосон цалинтай ажиллагчдын дундаж цалин нийт цалин улсын дунджаас 284.9 мянган төгрөг буюу 26.2 хувиар бага байна.

Ажилласан жил, гүйцэтгэлээр буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалыг үндэслэн тогтоосон ажиллагчдын **цалин хамгийн өндөр** буюу 1 156.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 12. Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, цалин тооцож буй нийт үзүүлэлт, мянган төгрөг

ААНБ-ЫН ЦАЛИН ТООЦОЖ БУЙ ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ ЦАЛИНГИЙН ДУНДАЖ	ҮНДСЭН ЦАЛИН	НЭМЭГДЭЛ	НЭМЭГДЭЛ ХӨЛС	ШАГНАЛ УРАМШУУЛАЛ
НИЙТ ДУНДАЖ ЦАЛИН	1087.7	913.1	108.3	56.1	10.2
АЖ УЧ ГХ АБ	1014.4	772.7	166.8	65.2	9.8
АЖ УЧ ГХ АБ	1127.9	1022.9	60.7	42.5	1.8
АЖ УЧ ГХ АБ	1031.6	941.5	53.6	33.6	2.8
АЖ УЧ ГХ АБ	1146.7	1004.8	78.9	49.4	13.6
АЖ УЧ ГХ АБ	1117.5	881.5	179.8	40.1	16.2
АЖ УЧ ГХ АБ	1010.9	813.5	117.2	73.6	6.5
АЖ УЧ ГХ АБ	1071.6	920.7	113.5	35.8	1.7
АЖ УЧ ГХ АБ	1162.1	1024.4	120.5	11.4	5.8
АЖ УЧ ГХ АБ	1167.1	884.6	147.9	119.7	14.9
АЖ УЧ ГХ АБ	1119.7	945.9	84.1	79	10.7
АЖ УЧ ГХ АБ	802.8	740.2	56.1	6.4	0.1
АЖ УЧ ГХ АБ	1112.8	967.3	142.4	0	3.1
АЖ УЧ ГХ АБ	1156.1	1148.7	6.2	0.4	0.9
АЖ УЧ ГХ АБ	1209	911.3	80.4	215.8	1.6
АЖ УЧ ГХ АБ	1129.4	840.8	215.4	68	5.1

- АЖ** Ажилласан жилээр
- УЧ** Ур чадвар, мэргэжлийн зэргээр
- ГХ** Гүйцэтгэлээр буюу хийснээр
- АБ** Ажил үүрэг, албан тушаал

ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр нийт цалингийн бүтцийг харвал хувьцаат компанийн ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 73.1 хувийг бүрдүүлж байгаа ч нэмэгдэл 12.2 хувь, нэмэгдэл хөлс 9.7 хувь, шагнал урамшууллын эзлэх хувь 5.0 байна. Судалгааны дүнгээр төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нэмэгдэл хамгийн өндөр хувиар олгодог байна.

ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын хүйсээр цалингийн бүтцийг харьцуулбал, эмэгтэй ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар эрэгтэй ажиллагчдынхаас 3.6-7.2 пунктээр өндөр байна. Харин тухайн хариуцлагын хэлбэрийн ААНБ-ын эрэгтэй ажиллагчдад нэмэгдэл болон нэмэгдэл хөлс шагнал урамшуулал илүү өндөр олгогддог байна.

Хүснэгт 13. ААНБ-уудын ажиллагчдын нийт цалингийн дундаж, салбараар, мян.төг

Байгууллагын хариуцлагын хэлбэр	Нийт цалингийн дундаж / мян төг/	Үүнээс: бүтэц, хувиар			
		Үндсэн цалин	Нэмэгдэл	Нэмэгдэл хөлс	Шагнал урамшуулал
Улсын дундаж	1087.7	84.0	10.0	5.2	0.9
Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	902.4	94.6	3.2	2.1	0.1
Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл	1159.4	87.9	4.3	7.8	0.0
Хоршоо	721.1	93.0	5.0	2.0	0.0
Хувьцаат компани	1358.9	73.1	12.2	9.7	5.0
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1130.3	92.5	3.9	3.3	0.3
Төрийн өмчит үйлдвэрийн газар	1325.7	65.4	22.8	8.8	3.0
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1036.4	76.2	21.6	2.0	0.1
Төсөвт байгууллага	994.2	73.1	18.4	7.3	1.1
Төрийн бус байгууллага	830.8	92.1	3.6	3.9	0.4
Бусад	1354.9	85.2	0.0	14.8	0.0

ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭ, ТҮҮНЭЭС БАГА ХЭМЖЭЭГЭЭР ЦАЛИННИЖ БҮЙ АЖИЛЛАГЧИД

Судалгааны мэдээлэл цуглуулах үе буюу 2021 оны 5-р сарын байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэг цагт 2500 төгрөг буюу сард 420.000 төгрөг байсан.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй бол эдгээр ажиллагчдын 94.6 хувь нь байнгын ажлын байранд, 5.4 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна.


Хүснэгт 14. Ажиллагчдын тоо, үндсэн цалин бүлгээр

Цалингийн бүлэг	Ажиллагчид	Хувь	Хүйсээр	
			Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	23087	100%	10912	12175
420.0 мянга хүртэл	1053	4.6%	575	478
420.0 мянга	1082	4.7%	608	474
420.1-500.0 мянга	1536	6.7%	662	874
500.1-600.0 мянга	2409	10.4%	1047	1362
600.1-700.0 мянга	2377	10.3%	1129	1248

700.1-800.0 мянга	4012	17.4%	1292	2720
800.1-1000.0 мянга	4534	19.6%	1883	2651
1000.1-1500.0 мянга	3810	16.5%	2253	1557
1500.1 мянгаас дээш	2274	9.8%	1463	811

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалингаар цалинжиж байсан ажиллагчдын сард ажилласан өдөр тус бүрээр авч үзвэл (судалгааны мэдээлэл цуглуулсан 5 дугаар сард ажлын 22 хоног байсан) 20 ба түүнээс доош өдөр ажилласан 23.7 хувь, 21-23 өдөр ажилласан 72.1 хувь, 4.1 хувь нь 24 ба түүнээс олон хоног ажиллажээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалинтай ажиллаж буй ажиллагчдын 14.3 хувь нь ажлын 22 өдөр ажилласан бол 9.6 хувь нь 1-10 өдөр хөдөлмөр эрхэлсэн байна.


Зураг 31. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнээс бага цалин авсан ажиллагчид, сард ажилласан өдрөөр



АЖЛЫН ЦАГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулсан 2021 оны 5 сарын байдлаар судалгаанд хамрагдсан 23087 ажиллагчдын 8.6 хувь буюу 1984 нь ажлын бус өдрөөр юм уу илүү цагаар ажилласан байна. Хамрагдсан ажиллагчдын 735 буюу 3.2 хувь нь ажлын бус өдрөөр, 1249 буюу 5.2 хувь нь илүү цагаар хөдөлмөр эрхэлсэн байна. Ажлын бус өдөр ажиллаж байсан ажиллагчид тухайн ажлын байранд сард дунджаар 3.4 өдөр, илүү цагаар ажилласан ажиллагчид сард дунджаар 39.3 цаг ажилласан байна.

Зураг 32. Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчид, ААНБ-ын хариуцлагын хэлбэр, хувиар



ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Түр ажлын байр гэж хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, тодорхой нэг ажил үүргийг гүйцэтгэснээр дуусгавар болдог, байнгын давтамжгүй, тохиолдлын шинж чанартай ажил үүрэг, албан тушаалыг;

Түр ажилтан гэж хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг "хувиараа хөдөлмөр эрхлэгч" гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

Үндсэн цалин: Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох баталгаат хөлсийг хэлнэ. Өөрөөр хэлбэл ажилтны хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан цалин болно.

Нийт цалин: Ажилтны ажилласан хугацааны, хөдөлмөрийн нөхцөл, албан ажлын онцгой нөхцөлийн цол зэрэг, эрдмийн зэргийн болон хамтын гэрээ хэлэлцээрээр, хөдөлмөрийн дотоод журам болон бусад эрхийн актын дагуу олгож буй хөлс.

Нэмэгдэл цалин: Ажилтны ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүрэг гүйцэтгэх, эсвэл албан тушаал хавсран болон хослон гүйцэтгэх, хуульд заасан ажлын цагаар илүү цагаар ажиллах зэрэг тохиолдлуудад ажил олгогчоос нэмэгдүүлэн олгож буй хөлсийг хамруулан ойлгоно.

Шагнал урамшуулал: Ажилтны ажлын үр дүн, эсхүл байгууллагын ажлын эцсийн үр дүнд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн ажил олгогчоос олгож буй мөнгөн урамшууллыг хэлнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 1995 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 2022-2023 оны хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, 2022 он
4. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
5. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2021 оны IV улирал Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2021 оны III улирал, 2021 он
10. Цалин хөлсний бүтцийн судалгаа, 2021 он

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

1. www.legalinfo.mn
2. www.nso.mn
3. www.1212.mn
4. www.mlsp.gov.mn/sp-dictionary
5. www.ndaatgal.mn/v1/
6. www.hudulmur-halamj.gov.mn